

## TRACK 2 БУЮУ ХОЁРДУГААР СУВГИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА

*Э.Батзориг\**

Мөргөлдөөн шийдвэрлэх хэмээхүйд үл ойлголцлыг нэг тийш нь болгох зорилгоор хэрэгжүүлж буй цогц үйл ажиллагааг ойлгож байна. Энх тайванд хүрэх тухай ойлголт эл процессийн зорилгын нэгээхэн хэсэгт оршиж буй нь гарцаагүй. Энх тайван гэдэг нь талууд цэрэг, эдийн засаг, улс төрийн хувьд тэнцүү байхдаа бус харин хоорондын харилцааны явцад хэн нэгэн илүү эрх эдэлж, илүүг олж авахгүй байх, өөрөөр хэлбэл өөрсдийн хэрэгцээ, хүсэл тэмүүлэл болон эрхээ эн тэнцүүгээр харилцан биелүүлж байхыг хэлэх болов уу. Энхийн төлөө тэмцэх гэдэг нь хүчирхийлэл, дайсагналыг багасгаж, итгэлцлийг бий болгож, тухайн харилцаан дахь талуудын хэрэгцээ, ашиг сонирхолд бодитой бөгөөд үнэн зөв хариулт өгөх явдал юм. Иймдээ ч энх тайван гэдэг нь дан ганц нэг талын мөрөөдлийн биелэлт бус харин харилцан хамтын ажиллагааны хүчин чармайлтын “үр дүн” юм.

Ерөнхийд нь энх тайвныг бий болгох ажиллагааг:

- Энхийг тохинуулах

- Энхийг тогтоох

- Энхийг сахиулах гэсэн гурван хэсэгт хуваан авч үзэж болох юм.<sup>1</sup> Эдгээрийн аль аль нь мөргөлдөөн шийдвэрлэх хэд хэдэн төрлийг илэрхийлнэ. Рональд Ж.Фишерийнхээр бол энхийг тохинуулах гэдэг нь “Илүү их итгэлцэл, хамтын ажиллагаа, гүн гүнзгий ойлголцол, хандлага, илүү таатай уур амьсгал болон улс төрийн хүсэл зориг зэргийг нэмэгдүүлэх замаар сөргөлдөгч талуудын харилцааг бэхжүүлэх оролдлого юм”<sup>2</sup> хэмээн тодорхойлсон бол энхийг тогтоох гэдгийг “Мөргөлдөгч талуудын хоорондын асуудлыг “уламжлалт дипломат аргаар” зохицуулахаар үндэстэн болон албан бус төлөөлөгчдийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ”<sup>3</sup> гэсэн байна. Эцэст нь энхийг сахиулах гэдэгт “Мөргөлдөгч талуудыг тус тусад нь хориглон тэвчиж, шууд хүчирхийллээс аль болох зайлсхийхийг чухалчлах замаар гуравлагч талыг уг харилцаанд оруулахыг хэлнэ”<sup>4</sup> гэжээ. Энхийг сахиулах ажиллагааны тод жишээ бол НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаа юм. Практикт түүнийг “хөх дуулга” гэх нь ч бий.

Үндэстний мөргөлдөөнийг шийдвэрлэхэд 2 үндсэн талбарын хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд нэгдүгээрт: улс төр-дипломатын,

\* Э.Батзориг - МУИС-ийн Хууль зүйн сургуулийн олон улсын эрх зүйн ангийн оюутан

хоёрдугаарт: хувийн хүмүүнлэгийн. Эдгээр категориуд нь тус тусдаа энхийг тогтоож чадах авч бас харилцан бие биесээ нөхцөлдүүлэх нь бий. Улс төр, дипломатын талбар дахь санаачлагыг гагцхүү удирдагчид гардан хэрэгжүүлдэг. Эдгээрт: аюулгүй байдал, иргэний болоод хүний эрх, эдийн засгийн тогтвортой байдал, түүний өсөлт, баялаг хуваарилалт болон хүчний туслалцааны талаархи хууль тогтоомж, удирдлагын асуудал багтдаг. Харин хүмүүнлэгийн талбарт эрх мэдэлтэн бус харин хүмүүс өөрсдөө гол тоглогч нь байдаг. Энд боловсрол, итгэл, хүндлэл, хүлээнгүй байдал зэрэг асуудлыг голлон авч үзнэ.

Энхийг бодитой тогтоохын тулд талуудын ашиг сонирхлын цөмийг тодотгож, түүнийг гүйцээх арга замыг хэлэлцэж, эцэст нь биелэлтийг хангах хэрэгтэй. Израиль-Палестины мөргөлдөөнийг дүгнэхдээ Марк Хеллер “Харилцан ойлголцолд хүрэхийн тулд юуны түрүүнд тус тусын ашиг сонирхлыг тодорхой болгох хэрэгтэй”-г дурьджээ.<sup>5</sup> Үнэхээр ч аливаа хэлэлцээг хөдөлгөгч хүч нь ашиг сонирхол байдаг гэдэгтэй эргэлзэх юм алга. Бодит ашиг сонирхол нь Палестины хувьд эрх чөлөө, Израилийнх аюулгүй байдлыг тогтоох явдал байсан гэдэг нь энхийг тогтоох үйл ажиллагааны явцад тодорхой болсон. Ашиг сонирхлыг хангахын тулд урт хугацааны энхийн хэлэлцээр байгуулах хэрэгтэй. Энхийн төлөө ажиллагааг тухайн ажиллагааны хэлбэр, зарчим, зорилгыг тодорхойлсон тохиролцоогоор эхлүүлэх нь зүйтэй. Ер нь энхийн хэлэлцээрийг төр засгийн хэмжээнд байгуулснаар хүчин төгөлдөр болдог хэдий ч, нөгөө талаас дан ганц мөргөлдөгч талуудын төрийн тэргүүнүүд баримт бичигт гарын үсэг зурснаар энхийг тогтоогоод, дархалчихна гэвэл ташаарсан ойлголт болох байх. Гэхдээ гарын үсэг зурах нь үйл ажиллагааны чухал хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Энхийн хэлэлцээрийн гол зорилго нь мөргөлдөгч талуудын ашиг сонирхлыг хангаж улмаар энхийн төлөө бүлгийг (peace constituency) бий болгох явдал юм. Энэ нь энхийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх нийгмийн идэвхитэй хэрэгсэл болно. Удирдагч нарын байгуулсан хэлэлцээрийн дүнд энх тайван нэг л удаа хүчээ авна. Харин нэгэнт авсан хүчийг бууруулах эсвэл хэвээр хадгалах нь гагцхүү хүмүүсээс өөрсдөөс нь шалтгаалах нь бий.

Палестин-Израилийн энхийг тогтоох Ослогийн хэлэлцээрийг байгуулах явцад гаргасан гол алдаануудын нэг бол энхийн талаархи хүмүүсийн үзэл санааг орхигдуулсан явдал байв. 1993 онд улс төрчид гэрээг байгуулахдаа хүний боловсрох, өмгөөлүүлэх, энхийн төлөө тэмцэх зэрэг хүчин зүйлсийг хаясан нь улмаар цуст тэмцлийн замналд хүргэсэн нь түүхэн үнэн.

Ослогийн “туршлагаас” дүгнэлт хийхэд энхийг тогтоох ажиллагаанд нийгмийн бүх давхаргыг хамруулах нь зүйтэй бөгөөд хоёрдугаар сувгийн буюу иргэний дипломат ажиллагааны үүрэг чухам энд оршиж байгаа юм.

### **Нэг. Хоёрдугаар сувгийн ба олон сувгийн дипломат ажиллагаанд тодорхойлолт өгөх нь**

“Track 2 diplomacy”<sup>6</sup> хэмээх нэр томъёог анх 1982 онд АНУ-ын Гадаад харилцааны албаны түшмэл асан Жозеф В.Монтвилль гаргасан. Иймээс ч хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааны тухай үзэл баримтлал сүүлийн 20 жилийн хугацаанд Америкт хурдацтайгаар хөгжсөн юм. Түүнийхээр бол хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа гэдэг нь “Сэтгэл зүйн хүчин зүйлсийн тусламжтайгаар мөргөлдөөнийг шийдвэрлэхэд чиглэсэн сөргөлдөгч бүлгүүдийн эсвэл үндэстний хооронд хийгдэх албан бус, бүтэцлэгдээгүй хөндлөнгийн оролцоо”<sup>7</sup> юм.

1987 онд<sup>8</sup> Монтвилль өөрийн гаргасан нэр томъёог 3 хэсэгт задлан өргөжүүлсэн юм. Асуудал шийдвэрлэх уулзалт, нийгмийн санаа бодлын нөлөөлөл, эдийн засгийн хамтарсан ажиллагаа<sup>9</sup> гэх мэт. Монтвиллийн санаан дээр тулгуурлан зарим эрдэмтэд, тухайлбал Жон Бюртон<sup>10</sup> “Өөрсдийн мөргөлдөөнийг шийдвэрлэх зорилгоор хүн ба материаллаг нөөцийг бий болгох, нийтийн санаа бодолд нөлөөлөх, стратегийг боловсруулахад чиглэсэн сөргөлдөгч талуудын бүтэг эсвэл үндэстний хооронд хийгдэх албан бус, энгийн хөндлөнгийн оролцоог хэлнэ”<sup>11</sup> хэмээжээ.

Монтвиллийн үзэл баримтлал дээр тулгуурлан “Олон сувгийн дипломат ажиллагаа”<sup>12</sup>-ны загварыг боловсруулсан хүн бол Жон Макдоналд<sup>13</sup> бөгөөд тэрээр хоёрдугаар сувгийг дөрвөн хэсэг болгон, өөрийн 5 сувгийн загварыг зохиосон юм. Шинэ загвараар бол суваг тус бүр олон улсын мөргөлдөөнийг шийдвэрлэж, хурцалмал байдлыг намжаахад чиглэсэн албан бус эсвэл иргэний дипломат ажиллагааг агуулна.<sup>14</sup> Гуравдугаар сувгийн ажиллагаанд сөргөлдөгч талуудын хооронд хувь болон хуулийн этгээдийн зүгээс хийгдэж байгаа бизнесийн үйл ажиллагаа орно. Хүйтэн дайны үед АНУ-Зөвлөлтийн харилцааг зөөлрүүлэхэд оролцож, хоёр орны худалдааны харилцаанд голлох үүрэг гүйцэтгэж байсан Америкийн бизнесийн пүүс *Arm&Hammer* нь дээрхийн сонгодог жишээ юм.<sup>15</sup> Дөрөвдүгээр сувагт иргэнээс иргэнд чиглэсэн солилцооны ажлууд, тухайлбал өөрийн зуу зуун судлаачдыг гадаад оронд очиж судалгаа явуулах, тэр хэмжээгээр зочин эрдэмтдийг АНУ-д зорчиж эрдэм шинжилгээний ажил эрхлэх боломжоор хангах зорилготойгоор 1946 онд АНУ-ын Конгрессын Актаар бий болгосон

Фулбрайтын хөтөлбөрийг дурьдаж болох юм.<sup>16</sup> Эцсийн буюу тавдугаар сувгийн ажиллагаанд мөргөлдөгч талуудын хүн ам, үндэстнийг гэгээрүүлэх зорилгоор ашиглаж байгаа мэдээллийн хэрэгсэл зэргийг багтаан ойлгоно. Олон улсын мөргөлдөөнийг хэрхэн зохицуулж болох боломжит хувилбаруудыг санал болгох зорилгоор 1989 онд CNN-ээр дэлхий дахинаа цацсан тус бүр 5 минутын 30 бүлэг телевизийн нэвтрүүлгийг жишээ болгон энд ярьж болно.<sup>17</sup>

Тодорхойлолт өгөх зорилготой сийрүүдсэн зүйлсээ ойлгомжтой болгох үүднээс буюу өөрөөр хэлбэл хоёрдугаар сувгийн буюу Иргэний дипломат ажиллагаа нь албаныхаас ялгагдах онцлогийг схемчлэн үзүүлье.

	1-р суваг	2-р суваг
Тоглогчид	Албан ёсны төлөөлөгчид, засгийн газар, үндэстэн дамнасан байгууллага, элитүүд, сөргөлдөгч талуудын удирдагчид	Албан бус төлөөлөгчид, төрийн бус байгууллага, бүсийн ба орон нутгийн удирдагчид, энгийн хүмүүсийн бүлэг
Арга	Эерэг эсвэл сөрөг өдөх шалтгаан, зуучлал, улс төрийн эсвэл эдийн засгийн дэмжлэг	Арын сувгийн хэлэлцүүлэг, боловсролын хөтөлбөр, уулзалт, энгийн хүмүүсийн эвлэрүүдэх үйл ажиллагаа
Мөргөлдөөний үе шат	Ерөнхийдөө бүх л шатанд оролцох боловч энхийг тогтоох болон энхийг сахиулах үед голлох үүрэгтэй.	Бүх шатанд оролцох боловч гол төлөв мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх ба энхийг тохинуулах үед тунхүү оролцоно.

### **Хоёр. Иргэний дипломат ажиллагаа практикт**

Мөргөлдөөн зохицуулалтын нэгэн цогц хэсэг нь хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа юм. Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааг бодлого тодорхойлогч болон тодорхой иргэдийн аль нь ч хэрэглэж болно. Бүх сувгийн гишүүд уулзалт, семинар болон яриа хэлэлцээ хийхэд оролцох боломжтой. Эдгээр үйл ажиллагаанаас гарах үр дагавар нь мэдээж өөр өөр байх. Нэгдүгээр сувгийн дипломат ажиллагааны хүрээнд хийгдсэн хэлэлцээ бусад сувгийнхийг бодвол илүү мөрдөгдөх шинжтэй байдаг бол нөгөө талаас хоёрдугаар сувгийн ажиллагааны хүрээнд хийгдсэн хэлэлцээ нь албан дипломат ажиллагаа явуулах үндсэн суурь болж өгдөг. Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааг олон улсын хөндлөнгийн оролцоо болгон хэрэглэхээс өмнө талуудын зорилго, ашиг сонирхлоос шалтгаалан хэрэглэгдэх үеийг нарийн тооцоолох шаардлагатай.

Мөргөлдөөн дэх хөндлөнгийн оролцооны хэлбэрээс хамаарч хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа нь хүчний тэнцвэр, цаг хугацаа болон тухайн мөргөлдөөний ерөнхий төлөв байдал зэрэг олон нөлөөлөлд автдаг. Дээрхи оролцооноос улбаалан хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааны тохиромжтой хэлбэр, боломжийг тодорхойлдог.

Хөндлөнгийн оролцоо нь улс төр-дипломатын, хүмүүнлэгийн, эдийн засгийн ба цэргийн гэсэн үндсэн 4 төрлийн хэлбэртэй. Үүссэн нөхцөл байдлын талаар аливаа улс өөрийн байр суурийг илэрхийлж

байгаа үед улс төр-дипломатын, мөргөлдөөний улмаас хохирсон иргэдэд тусламж (эмнэлэг, хүнс, хувцас, хоргодох байр ба бусад) үзүүлэх үед хүмүүнлэгийн, сөргөлдөгч талуудын аль нэгэнд нь санхүүгийн тусламж үзүүлэх, эсвэл эдийн засгийн хориг тавих замаар эдийн засгийн, эцэст нь мөргөлдөөний цар хүрээ хэмжээнээсээ хэтэрсэн үед хүч хэрэглэснээр цэргийн оролцоо тус тус эхэлнэ. Цэргийн оролцоо ер нь эрсдэл ихтэйгээс гадна ихээхэн сөрөг үр дагавартай байдаг. Бодлого тодорхойлогч дээрхи дөрвөн аргын алийг ч сонгон хэрэглэж болно.<sup>18</sup>

Үүссэн нөхцөл байдалд тохирох хөндлөнгийн оролцоог тодорхойлох нэг гол хүчин зүйл бол цаг хугацаа юм. Мөргөлдөөн явцын дунд намжиж болно, эсхүл бүр хурцдаж болно. Иймд хөндлөнгийн оролцоог аль болох эрт эхлүүлэх нь асуудлыг хялбарчлаж, зардал хэмнэхээс гадна, хамгийн гол нь илүү нааштай байдлыг бий болгох ач холбогдолтой.

Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа нь оролцогчид, бодлого тодорхойлогчдын хоорондын харилцаа болон хөндлөнгийн оролцооны бие даасан байдал гэсэн үндсэн хоёр шинжээр тодорхойлогдоно. Хоёрдугаар сувгийн даллагажигч нар нь бодлого тодорхойлогчидтой тогтоосон харилцаандаа гүнзгий нөлөөлөл үзүүлж чадахуйц хэмжээнд боловсрогдсон мэргэжлийн хүмүүс байвал зохино. Тэрхүү гүнзгий нөлөөллөөс мөргөлдөөний хувь заяа шалтгаалах нь мэдээж. Албаны дипломат ажиллагааг бодвол асуудлыг шийдвэрлэх шийдлийн олон төрлийг агуулдагараа хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа нь давуу талтай. Ер нь эцсийн дүндээ ямарваа нэгэн маргаан, үл ойлголцлыг энхийн аргаар шийдвэрлэх боломжийг эрэлхийлэхэд хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааны зорилго оршино. Зорилгодоо хүрэх хэлбэр нь уулзалтын ба хэлэлцээний гэсэн хэсгүүдтэй.

Уулзалт нь даллагажигч нарыг бэлтгэх сургалтын үйл ажиллагааны чухал үе шат болох хувьдаа мөргөлдөөн шийдвэрлэх таатай орчныг бий болгодог.<sup>19</sup> Херберт Ц.Келманыхаар<sup>20</sup> бол уулзалт нь үндсэн хоёр зорилгыг өөртөө агуулж байх хэрэгтэй ажээ. Нэгд, оролцогчид нь юуны өмнө өөрсдийгөө болон тухайн мөргөлдөөнийг үзэх үзлээ өөрчлөх, цаашлаад түүнийг “анагаах” хуучинсаг арга барилаас татгалзах хэрэгтэй. Хоёрт, үүссэн шинэ чиг хандлагыг тухайн нийгэмлэгүүдийн оролцоотойгоор улс төрийн буюу шийдвэр гаргах шатанд хэлэлцүүлэхээр шилжүүлэх боломжийг нэмэгдүүлэх.<sup>21</sup> Мөргөлдөөний онцлог, статусаас хамаарч уулзалтын сэдвийг тодорхойлно. Айлин Ф.Бабит урьдчилан сэргийлэх, зохицуулах, мөргөлдөөний дараах болон хамтарсан гэсэн хувилбаруудыг санал болгожээ. Урьдчилан сэргийлэх сэдвийн хүрээнд талуудын хооронд

гал дүрэлзэхээс өмнөх үеийн асуудлыг хөндөнө. Нөхцөл байдал нэгэнт ширүүссэн бол түүнийг хурцагтахаас сэргийлэх үүднээс зохицуулах сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж болох юм. Талуудын харилцааг сэргээх зорилгоор мөргөлдөөний дараах асуудлаар маргаж болох бол мөргөлдөөний тархалтаас урьдчилан сэргийлэх ба энэ нь оролцогч бүх талуудын хамтын үүрэг гэдгийг тогтоох зорилгоор олон оролцогч бүхий тогтолцоог байгуулахад чиглэсэн хамтарсан хэлбэрээр нөхцөл байдалд хандах бололцоотой юм.<sup>22</sup>

Дараалал ёсоор хамгийн түрүүнд хийх ёстой ажил бол талуудыг уулзалтын ширээний хоёр талд өөд өөдөөсөө харан сууж байх бүхий л нөхцлийг бүрдүүлэх явдал болох тухай санал Роналд Ж.Фишерийн бүтээлүүдэд ажиглагдана. Жишээлбэл уулзалтыг ямаршуухан хэлбэрээр эхлүүлж болох тухайд “Юуны түрүүнд уулзалтын өмнө талуудад харилцан бие биеийг таних бололцоог олгох хэрэгтэй. Харин уулзалтыг талууд мөргөлдөөний талаархи өөрсдийн байр суурийг илэрхийлэх хэлбэрээр эхлүүлэх буюу залгуулаад асуудлыг шийдэж болохуйц, харилцан хүлээн зөвшөөрөгдөхүйц шийдэл бий эсэхийг судлах нь зүйтэй болов уу. Эцэст нь үүссэн нөхцөл байдлыг хэрхэн даван туулах тухай болон шийдэлд хүрсэн бол түүний хэрэгжилтийг хэрхэн хангах тухай хэлэлцүүлэг явуулах хэрэгтэй”<sup>23</sup> хэмээсэн бий.

Ерөнхийдөө уулзалт нь долоо хоногийн турш мөргөлдөгч талуудын гишүүдийг харилцан нүүр тулах, мэтгэлцээний явцад өөрсдийн байр суурийг илэрхийлэх буюу хамгаалах зэрэг сэтгэл зүйн тулаанд оруулдаг. Иймээс уулзалтыг өдөр тутмын нэгэн хэвийн нөлөөллөөс аль болох тусгаарлаж өгөх үүднээс төвийг сахисан байдалд буюу бусад гуравдагч орны нутаг дэвсгэр дээр голдуу зохион байгуулах нь бий. Сөргөлдөгч улсуудын төлөөлөгчид, эвлэрүүлэгчид болон зочин улсын зуучлагч нар гол төлөв оролцогчдыг бүрдүүлдэг. Уулзалтыг 3-4 өдөрт амралтын газар эсвэл зочид буудалд зохион явуулна. Монтвиль Келманы хамтаар эвлэрүүлэгчийн хувиар уулзалтанд оролцож явсны хувьд өөрийн туршлагаас хуваалцахдаа “Оролцогчид нь бүгдхурлын буюу эсвэл жижиг ажлын хэсгийн хэлбэрээр уулздаг. Тэд нэгэн цагт хооллох ба үүний дараа урьдчилан бэлтгэсэн аялал, концерт, жүжиг болон бусад амралтын үйл ажиллагаанд оролцоно. Дээрхийг хоёр өдрийн уулзалт, залгуулаад нэг өдрийн амралт, уулзалтын сүүлчийн хоёр өдөр ба үдэлтийн зоог гэсэн дараалалтай гэж ойлгож болно. Үүнээс гадна оролцогчдод нүүр тулан уулзах цаг гаргаж өгөх нь бий. Жуулчлалын төвүүдээр автобус болон завиар зулаалга хийх үед зарчмын шинжтэй ач холбогдол бүхий чухал асуудлыг хөндөж байдаг”<sup>24</sup> гэжээ.

Үүнээс үзэхүл уулзалтанд бодлого тодорхойлогчоосоо эхлэн энгийн иргэн хүртэл нийгмийн бүхий л түвшингээс хамрагдаж байна.

Уулзалт нь эрдмийн ажил, семинар, конференци, яриа хэлэлцээ зэргүүдэд оролцох хоёрдугаар сувгийн дадлагажигч<sup>25</sup> нарыг бэлтгэх сургалтын гол хэрэглүүр болдог. Сургалтын процесс нь хоёр үндсэн зорилтоос бүрдэнэ. Эхнийхийг нь Монтвилль “нийтийн санаа бодолд нөлөөлөх”<sup>26</sup> гэсэн. Бүдүүн тоймоор ойлговол бусад бүх сувгийн тусламжтайгаар нийгэмд энхийн тухай үзэл санааг суулгана гэсэн үг. Гол нөлөөлөл бодлого тодорхойлогч ба шийдвэр гаргагчид тийш чиглэж байх явцад нэг болон хоёрдугаар сувгийн дадлагажигч нар өөрсдийн мэдлэг оюун, туршлагыг энгийн хүмүүсийн бүлэг болон бусад оролцогчдын үйл ажиллагааг дэмжихэд зориулна.

Уулзалт хэмээхүйг базаж үзвэл нэг нэгнийхээ байр суурь, үзэл баримтлалыг нэвт ойлгож, тэдгээрийг зөвшитгөх арга замыг тодорхойлж, албан ёсны түвшинд харилцан хэрэглэгдэхүйц шийдлийг тогтоох явдал мөн. Харин тэрхүү шийдэлд хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааны хэрэгсэл болсон хэлэлцээ хийх замаар хүрнэ.

Сургалтын процессын хоёр дахь зорилго бол хоёрдугаар сувгийн дадлагажигч нарыг хэлэлцээний шатанд бэлтгэх явдал юм. Олон жилийн сургалт, дадлага нь хэлэлцээ явуулах улмаар бодлого тодорхойлогчдод хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд хэлэлцээр байгуулах чадварыг олгоно. Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаан дахь хэлэлцээний шат нь хэд хэдэн зүйлээрээ уулзалттай төстэй. Эдгээр нь хоёул төвийг сахисан, аливаа нөлөөлөлгүй орчинд явагддаг. Даалгавар дээрээ анхаарлаа төвлөрүүлэхийн тулд оролцогчид нь амралтын болоод зочид буудалд тусгаарлагдсан байх ёстой. Бүхий л төрлийн мэдээлэл, ажлын хэрэглэл, тусламж болон нарийн бичгийн дэмжлэгийг ямар ч саадгүйгээр олж авах эрхтэй гэх мэт. Уулзалт ба хэлэлцээн дэх гол ялгаа нь асуудалд хандах хандлаганд оршино. Уулзалтаар мөргөлдөөний мөн чанарыг авч үзэх бол хэлэлцээний явцад шууд улс төрийн үр дагаварт хүрэх асуудлыг голлодог. Хэлэлцээний шатны эцсийн зорилго нь хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааны явцад байгуулсан хэлэлцээрийг нэгдүгээр сувгийнханд хүлээлгэн өгөх явдал юм. Хоёрдугаар сувгийн дадлагажигч нар нь бодлого тодорхойлогчидтой гүнзгий харилцаа тогтоосон тохиолдолд тэдний нэрийн өмнөөс хэлэлцээ явуулж болно. Нэмж хэлэхэд хэлэлцээний явцад хэрэглэгдэх дипломат ажиллагааны түвшинг тодорхойлох хоёр хүчин зүйлийг тогтооно. Үүнд: бодлого тодорхойлогчидтой тогтоох харилцаа ба тодорхой үйлдэл эрхлэн хийх бие даасан (autonomy) байдал зэрэг орно. Дадлагажигчид байгуулсан хэлэлцээрээ тус тусын улс төрийн удирдагчдад танилцуулсны дараа үргэлжлүүлэн албан хэлэлцээний багт орно. Ингэснээр өмнө тогтоосон бүлээн уур амьсгалыг ашиглан бодит хэлэлцээ (official) явуулан улмаар зайлшгүй мөрдөгдөх хэлэлцээрийг байгуулахад нь нэгдүгээр сувгийнханд дөхөм болох учиртай.

### **Гурав. Хоёрдугаар сувгийн дадлагажигч гэж хэн бэ?**

Хариулт авахын тулд дадлагажигч, мөргөлдөгч талуудыг төлөөлөн оролцогч хоёрын ялгааг гаргах хэрэгтэй. Юуны өмнө тэдгээр хоёул хангалттай түвшинд бэлтгэгдсэн, төлөөлүүлж буй талдаа холбогдох талбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн хүмүүс байх чухалтай. Ихэнхи тохиолдолд дадлагажигч нар нь мөргөлдөөний асуудлаар дагнан сургалт, судалгаа эрхлэн явуулдаг эрдэмтэд байдаг. Оролцогчид оюуны болоод онолын өндөр чадвартай байхаас гадна Ph.D эсвэл J.D зэрэгтэй байхыг Даймонд, Макдоналд нар зөвлөснийг энд дурьдахад илүүдэхгүй. Харин Келман оролцогчыг тухайн хэлэлцүүлэгт улс төрийн шинжийг цухалзуулж, заримдаа бүр улс төрийн нөлөөлөл (гэхдээ үүнийг албан ёсны бус гэж ойлговол зохино) үзүүлж байдгаар нь онцолсон.<sup>27</sup> Хоёрдугаар сувгийн дадлагажигч нарын нэг гол шинж нь тэдний бодлого тодорхойлогчидтой тогтоосон харилцаа юм. Ер нь аль ч шатны ямар ч асуудалд нөлөө үзүүлэхүйц байхын тулд дадлагажигч нь бодлого тодорхойлогчдын зүгээс тодорхой хэмжээний хүндэтгэл хүлээсэн этгээд байх хэрэгтэй. Шууд харилцаагүйгээр ямар нэг харилцан нөлөөлөл бүхий үйл ажиллагаа явуулах, цаашлаад олон сувгийн дипломат ажиллагааг идэвхижүүлэх тухай бодоод хэрэггүй болов уу! Ухаан нь тэрхүү үйл ажиллагаа нь нэг талаас хоёрдугаар сувгийн талбарт ажиллах этгээдийг сонголттойгоор шилж авах боломжийг бодлого тодорхойлогчдод олгох, нөгөө талаас өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлагын тусламжтайгаар улс төрийн удирдлагад нөлөөлөх боломжийг уг дадлагажигч нарт олгодог.

Бодлого тодорхойлогч ба дадлагажигч нарын эрх (боломж) нь харилцан биесээ нөхдөгийн (давуу тал) хувьд энхийн санаачлага гаргахад чухал үүрэгтэй. Нэгдүгээр сувгийнханд ямар ч тохиолдолд эрх нь байх бол хоёрдугаар сувгийнханд асуудлыг шийдвэрлэх олон хувилбар бүхий сонголтууд байдаг. Фишер энэ тухайд “Оролцогчид гол шийдвэр гаргагчидтай аль болох ойр байж тэдэнд зохих хэмжээнд нөлөөлж байх, мөн улс төрийн ямар нэг “тусгалаас”-аас цочрохгүйгээр үр дүнд хүрэх бололцоотой хувилбаруудыг боловсруулах хэрэгтэй. Шууд шийдвэр гаргах эрхгүй ч аль ч шатанд нөлөө бүхий этгээд нь хэлэлцээний нэгэн хэв маягт баригдахгүйгээр аль болох уян хатан, хөрвөлт сайтай байх зарчмыг баримтлаж, үйл ажиллагаа нь бүтэлгүйтсэн тохиолдолд албан ёсоор оролцоогоо зогсоох чадвартай байдаг”<sup>28</sup> хэмээсэн буй.

Эцсийн дүндээ бодлого тодорхойлогчид нь мөргөлдөгч талуудын хувьд заавалчгүй мөрдөгдөх хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэх хүчийг агуулдаг боловч тэдний үйл ажиллагаа улс төрийн хязгаарлалтад

өртөх нь бий. Дадлагажигч нар нь бодлого тодорхойлогчид ба тухайн нийгэмд зэрэг нөлөөлөх чадвартай бөгөөд ингэснээрээ хэдийгээр хуулийн эрхийг агуулдаггүй ч бусад сувгуудад зохих хэмжээгээр хатгаас өгч, тэдгээрийг хөдөлгөөнд оруулдаг.

### **Дөрөв. Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаан дахь зуучлал**

Зуучлагч нь албан бус дипломат ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хоёрдугаар сувгийн оролцооны үндсэн хэлбэрүүд болох уулзалт болон хэлэлцээний үе шатанд талууд гол төлөв мөргөлдөөний онол, практикийн асуудлаар зэгсэн мэдлэг хуримтлуулсан этгээдийг оролцуулах бодлогыг түлхүү баримтладаг. Сөргөлдөгч талуудаас нэг төлөөлөгч, эсвэл мөргөлдөөнд төвийг сахисан гуравдагч тал гэх мэт. Үүнээс гадна албан ёсны төлөөлөгч, эсвэл хоёрдугаар сувгийн дадлагажигч нь зуучлагч байж болно. Практикаас харахад сайн дурын төлөөлөгчдийн хамтаар төвийг сахигчид энэ үүргийг маш сайн гүйцэтгэдэг.

Мөргөлдөөнийг даамжруулах буюу хурцатгахаас, мөн шинээр үүсч болзошгүй үйл явдлаас урьдчилан сэргийлэх гуравдагч талын оролдлого<sup>29</sup> хэмээн Жел Скжелсбек, Гунар Ферман нар зуучлалыг тодорхойлсон байх юм. Хоёрдугаар суваг дахь зуучлагчийн үүрэг, зорилго нь ихэвчлэн түүний хувийн шинж болон оролцооны хэлбэрээс шууд хамаардаг. Женон Воккер хатуу ба зөөлөн гэсэн зуучлалын хэлбэрийг санал болгожээ. Хатуу хэлбэр нь тодорхой маргаанд тодорхой шийдлийг хайхад чиглэж байх тул илүүтэйгээр нэг ба хоёрдугаар сувгийн хүрээнд эргэлддэг. Харин зөөлөн хэлбэрийн ажиллагаа нь угсаатны мөргөлдөөний үед нийгэмд бүлээн уур амьсгалыг бий болгож, талуудын харилцааг сэргээхэд оршиж байх тул гурав ба дөрөвдүгээр сувагт хамаарна.<sup>30</sup>

Зуучлалын гол зорилт бол мөргөлдөгч талуудын хооронд харилцаа холбооны сувгуудыг тогтоон барих явдал юм. Брайнт Веж энэ талаар “Сөргөлдөгч бүлгүүдийн хооронд харилцах “гүүр” тогтоох ба түүнийг институтчлах явдал нь тэдний зорилт байх ёстой. Нөгөө талаас тэр гүүр нь талуудын соёлын хэв шинж, үндэсний маягт харшлах буюу саад хийхгүй байхад чиглэх хэрэгтэй”<sup>31</sup> гэсэн бол “Гуравдагч талын (зуучлал) даалгавар нь үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, түүн дотор нааштай уур амьсгалыг бий болгож улмаар хэм хэмжээ тогтоох ба эцэст нь гэнэтийн ашигтай хувилбаруудыг санал болгох явдал” хэмээн Келман уулзалтаар жишээ татан зуучлагчийн үүргийг тодорхойлжээ.<sup>32</sup> Вежийн туршлагад тулгуурлан зуучлагчийн оролцооны

таван шаг бүхий ерөнхий загварыг Фишер томъёолсон. Эхний удаад талуудыг холбож яриа хэлэлцээ явуулах талаар санаачлага гаргана. Дараагийн ээлжинд талуудын байр суурь, хэрэгцээ, шаардлага ба хүсэл тэмүүлийг тодорхой болгож өгнө. Дунд шатанд төвийг сахисан орчинд сөргөлдөгч талуудын төлөөлөгчдийг хэлэлцээний ширээнд суулгана. Дөрөвдүгээр шатанд хамтарсан хөтөлбөрийг батлан гаргах ба эцсийн дүнд бодит хамтарсан төслийг хэрэгжүүлэх үүднээс зуучлагч тоглолтоос албан ёсоор гарах.<sup>33</sup> Үүнийг нэгтгэн хэлбэл хэлэлцээний явцад оролцогчид мөргөлдөөн ба ямар ч үр дүнгүй улс төрийн мэтгэлцээнээс ангид байх талаар сэтгэл зүйн задлан шинжлэл (psychoanalysis) хийхэд нь зуучлагч “газарчин”-гийн үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн үг.

Хоёрдугаар сувгийн оролцоон дахь гол бөгөөд үр дүнтэй нэгэн элемент бол төвийг сахисан орчин юм. Уулзалт ба хэлэлцээний аль алийг нь мөргөлдөөн ба өдөр тутмын саад тогтоороос аль болох ангид орчинд явуулахад өгөх үр дүн нь эерэг байх магадлалтай. Якоб Беркович, Аллисон Хьюстон нар зуучлалын орчинг дараах байдлаар дүрсэлжээ.

Хэвлэл мэдээллийн (сурвалжлагч, сэтгүүлч, зурагчин гэх мэт) нөлөөлөл, гадаад дарамт зэргээс ангид. Ийм орчин нь дэг журмын болоод дэс дарааллын удирдлагыг атах бололцоог зуучлагчид, асуудалд анхаарлаа төвлөрүүлж, түүнд ул суурьтай хандах боломжийг талуудад олгодог. Төвийг сахисан орчинд зуучлагч нь талуудад мэдээлэл олж авах чөлөөт, эрх тэгш боломжийн баталгаа өгөх, талуудын харилцаа холбоог найдвартай барих ба шаардлагатай бол талуудын хүчний ялгааг тэнцвэржүүлэх замаар тоглоомын талбарын түвшинг тогтоож болно.<sup>34</sup> Беркович, Хьюстон нар оролцооны хэлбэлзлээс хамаарч зуучлагч үйл ажиллагаа явуулах гурван стратегийг боловсруулсан байна. Холбоо-дэмжлэгийн стратегийн хүрээнд зуучлагч нь талуудын хооронд мэдээлэл дамжуулах зэрэг пассив ажлыг амжуулна. Процедурын стратегийн дагуу зуучлагч байрлал, хэлбэр, хэлэлцүүлэгийн сэдэв зэрэг оролцоонд хамаарах асуудлыг хариуцах бол оролцооны хөтөлбөрийг батлахаас гадна хэлэлцээг үр дүнтэй болгох үүднээс бүхий л нөөцийг ашиглаж, нөлөөллийн бүхий л аргыг хэрэглэх үүрэг эцсийн чиглүүлэн-удирдах стратегид багтана. Сүүлчийн стратеги нь албан дипломат ажиллагаанд ч чухал байр суурь эзэлдэг гэдгийг энд дурьдах нь зүйтэй.<sup>35</sup> Хоёрдугаар сувгийн оролцооны хэлбэрээс хамааран зуучлагч нь өөр өөр үүрэг гүйцэтгэдэг. Зуучлагч дараах таван төрлийн үндсэн үүргийг гүйцэтгэж болно гэж Хопман үзэж байна. Юуны өмнө зуучлагч талуудад хэлэлцээр байгуулах урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ. Энэ үүргийн ач холбогдлыг ихэнхдээ хэлэлцээний шатанд үзэж болно. Харилцаа холбоо тогтоох, харилцан буулт хийх боломж бий эсэх, түүнчлэн талуудын байр

суурийг нийцүүлэх ажлыг удирдан явуулна. Энэ нь улзалтын шатанд үр дүнгээ өгнө. Мөргөлдөөнийг өөрчлөх буюу түүнийг зогсооход чиглэсэн шинэ бөгөөд өгөөжтэй арга замыг хайхад түүний гурав дахь үүрэг оршино. Томъёологчын үүрэг гүйцэтгэж болно. Үүргийн гүйцэтгэлийг гол төлөв хэлэлцээний шатанд хангах ба маргааныг таслан зогсоох боломжит шийдлийг олоход чиглэнэ. Зуучлагч өөрийн мэдлэг, алсын харааг ашиглан асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх гольдролд сөргөлдөгч талуудыг татан оруулах үүргийг эцэст нь гардан хэрэгжүүлнэ.<sup>36</sup> Дүгнэж үзэхэд зуучлал нь бүхэлдээ талууд ба зуучлагчдын харилцан нөлөөллийн хүрээнд явагдаж байна. Маргалдагч талуудын хэрэгцээ, сонирхол харилцан адилгүй байдлаас зуучлалын процедурыг урьдчилан төлөвлөх боломжгүй байдаг. Мөргөлдөөнийг илааршуулах эсэх нь ихэнхи тохиолдолд зуучлагчаас шалтгаалдаг тул түүнд “алдаж буудах” эрх байхгүй.

### **Тав. Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаанд нөлөөлөх бусад хүчин зүйлс**

Хоёрдугаар сувгийн дадлагажигч нар үйл ажиллагаанд оролцож эхлэх таатай мөчийг тодорхойлоход бусад төрлийн хүчин зүйлсийн нөлөө бас байх. Мөргөлдөөний статус, хурцалмал байдлаас сэргийлэх боломж, мэдээллийн үүрэг зэргийг энд дурьдаж болно. Гаргасан санаачлагыг ажил хэрэг болгоход эдгээрийн үзүүлэх нөлөөг хэлээд баршгүй. Улс төрийн удирдлага явцгүй болж талуудын хооронд үл ойлголцол үүсэх үед хоёрдугаар сувгийн дадлагажигчид бусад сувгийнхны хамтаар энхийг тогтоож улмаар үйл ажиллагаа нь бүтэлгүйтсэн тэдэнд шинээр зөв эхлэх бололцоог олгодог. Угаасаа мөргөлдөөн нь өөрийн динамик, үе шат болон хүчирхийллийн мөчлөгтэй. Улс төр, нийгмийн динамик, бэлэн нөөц болон гадаад тоглогч зэргүүд нь мөргөлдөөний статуст нөлөөлдөг. Жеффри З.Рубин мөргөлдөөний оршил, өрнөл, төгсгөл гэсэн гурван үе шат байж болох талаар санаа дэвшүүлснийг энд дурьдахад: эхний шатанд талууд буюу хөндөх асуудлыг танилцуулна. Дунд шатанд талуудыг мухардалд оруулаад буй эсрэг тэсрэг байр суурийн талаар халуун яриа өрнөдөг бол гугаар буюу төгсгөлийн шатанд хэлэлцээ хийх замаар сөргөлдөгч талуудад харилцан зөвшөөрөгдөхүйц шийдлийн хувилбарыг баталснаар мөргөлдөөн намжих тал руу хэлбийж эхэлдэг.<sup>37</sup> Дипломат оролцоог сонгох үед цаг хугацаа гол элемент болно. Дипломат ажиллагааг аль ч түвшинд илэрхийлж, түүнд шууд нөлөө үзүүлж байдаг бас нэгэн хүчин зүйл бол мэдээллийн хэрэгсэл юм. Дайныг эсэргүүцэж, энхийг эрхэмлэсэн дуу хоолойг дэлхий дахинаа цацаж, цацсан мэдээлэл нь нийгмийн

давхарга болгонд хүрдэгт түүний хүч оршиж байгаа юм. Үүнийг бас нийгмийг гэгээрүүлэх ажиллагаа ч гэж ойлгож болно.

### **Дүгнэлт**

Хоёрдугаар сувгийн дипломат ажиллагааг ихэвчлэн ашиг сонирхлын зөрчлийн улмаас хоёр буюу түүнээс дээш улсуудын хооронд ассан мөргөлдөөний галыг унтраах зорилгоор ашиглаж байдаг нь нэгэнтээ тогтсон практик. Ихэвчлэн гэсэн нь ашиг сонирхлоос өөр хүчин зүйлс бас үл ойлголцолд хүргэдэг гэснийг тодотгох гэсэн санаа болно. Нэг улс нөгөө улстай дипломат харилцаа тогтоох нь шинжлэх ухаан, соёл, урлаг, боловсролын гээд олон салбарт хамтарч ажиллах, улмаар тэдгээрийн үр шимийг хүртэх боломжийг хүмүүст олгож байна гэсэн үг бол нөгөө талаас дээрхи салбаруудын хүрээнд харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хоёр орныг холбогч гүүр болсон дипломат харилцааг зузаатгах хүчин зүйл болно. Товчоор хэлбэл улс орнууд иргэний дипломат ажиллагааг төрийн дипломат ажиллагааг өргөтгөн идэвхижүүлэх нэгэн суваг болгон ашигладаг гэсэн үг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд унагаж асан хэд хэдэн ноцтой үйлдэл гарсан. Ингэснээр хууль тогтоомжийг нь зөрчиж байгаа нь өөрийг нь илтэд үл хүндэтгэж буйн илрэл гэсэн ойлголтыг тухайн улсад төрүүлэх нь дипломат харилцаанд хичнээн сэвтэйг хэлээд барахгүй. Хэдий албан ёсоор уучлалт гуйсан ч урьдын найрсаг харилцааг шууд сэргээчихнэ гэдэг бас хэцүү. Сонгодог, уламжлалт аль ч онолын үүднээс үзсэн орчин үеийн олон улсын харилцаа тэр чигээрээ харилцан итгэлцэл дээр явагддаг гэдэгтэй маргах хүн гарахгүй биз. Манайхан олон улсын хэмжээнд маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, гол дүрд нь тоглоод байдаггүй юмаа гэхэд ихэнхидээ хувь хүний ёс бус зан үйлээс угшилтай бусармаг ажиллагаанаас учирсан “хохирол”-ыг илааршуулах үүднээс иргэний дипломат ажиллагааг өргөнөөр ашиглахад болохгүй гэх газаргүй. Монгол Улсаас ОХУ-д сууж асан элчин сайд нэгэнтээ Японд айлчлах үеэр сумочдыг Монголын дипломатч гэж байсныг өгүүлийг тэрлэгч миний бие тод санаж байна. Үнэхээр нэг л жишээ татахад өмнө дурьдсан хүмүүсийн болчимгүй үйлдлээс болж бөмбөршгийн нэг талд шалдаа бууж буй манай улсын нэрийг хүндийг дам байдлаар нөгөө талд дэвтээж байгаа “буянтнууд” бол арлын оронд, цаашлаад тив дэлхийд эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөж яваа сумочид мөн. Эцэст нь хэлэхэд Монгол Улс энхийг эрхэмлэсэн гадаад бодлогынхоо хүрээнд олон улстай хөл нийлүүлж, даяаршлын жимээр хамтдаа урагшлахад хоёрдугаар сувгийн санаачлага гаргах нь чухал гэдэгт эргэлзээ алга.

**Ашигласан материал**

1. “Three Approaches to Peace: Peacekeeping, Peacemaking and Peacebuilding” In J.Galtung, Peace, War and defense: Essays in Peace Research II, Copenhagen: Christian Ejlars. 282-304 дэх тал
2. Ronald J.Fisher. Interactive Conflict Resolution. (Syracuse, New-York5 Syracuse University Press, 1997), 11 дэх тал
3. Мөн тэнд, 10 дахь тал
4. Мөн тэнд, 11 дэх тал
5. Mark Heller and Sari Nusseiba. No Trumpets, No Drums. (Hill and Wand, 1993), 20 дахь тал
6. Өдгөө энэ үгийг хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа, иргэний дипломат ажиллагаа, ардын дипломат ажиллагаа гэх мэтээр монгол хэлнээ буулгаж байна.
7. Fisher, Interactive Conflict Resolution. 117 дахь тал
8. Joseph V. Montville. “The Arrow and The Olive Branch: A Case For Track Two Diplomacy” Conflict Resolution: Track Two Diplomacy, eds. John W. McDonald and Diane B. Bendahmane Washington, DC.: Foreign Service Institute, 1987.
9. Fisher, Interactive Conflict Resolution. 117 дахь тал
10. Жон Бюртон Австралийн Гадаад харилцааны албанд зүтгэж байсан мөн 1983-1985 онуудад Мариландын Их сургуулийн Олон улсын Хөгжлийн Төвд Мөргөлдөөн шийдвэрлэх төслийн удирдагч хийж байсан.
11. Mohamed Rabie. Conflict Resolution and Ethnicity. (Westport, Connecticut: Praeger, 1994), 95 дахь тал
12. Fisher, Interactive Conflict Resolution. 118 дахь тал
13. Элчин сайд Жон.Макдоналд Өрнөд Европ ба Дундад Азийг хариуцан Гадаад харилцааны албанд 40 шахам жил ажилласан.
14. Мөн тэнд.
15. <http://www.colorado.edu/conflict/peace/example/mcdo3682.htm>
16. John W.McDonald, “Further Exploration of Track Two Diplomacy.” In Timing the de-escalation of International Conflicts, (Ed.) Louis Kriesberg & Stuart J. Thorson, (Syracuse, NY5 Syracuse University Press, 1991), 205 дахь тал
17. Мөн тэнд.
18. Steven L.Burg and Paul S.Shoup. The war in Bosnia-Herzegovina: Ethnic Conflict and International Intervention. (Armonk, NY5M.E.Sharpe, 1998), 398-407 дахь тал
19. Joseph V. Montville. “The Arrow and The Olive Branch: A Case For Track Two Diplomacy” Conflict Resolution: Track Two Diplomacy, eds. John W. McDonald and Diane B. Bendahmane Washington, DC.: Foreign Service Institute, 1987. 9 дэх тал
20. Херберт Ц.Келман бол Харвардын их сургуулийн Нийгмийн угсаатан судлалын профессор, мөн сургуулийн Олон улсын харилцааны төвийн Олон улсын мөргөлдөөнд дүн шинжилгээ хийх, түүнийг шийдвэрлэх төслийн удирдагч юм. Тэрээр Ойрхи-

Дорнодын улсуудын мөргөлдөөний асуудлаархи судалгааны хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцож ирсэн бөгөөд асуудал-шийдвэрлэх уулзалтын хэлбэрийг үндэслэгчдийн нэгд зүй ёсоор тооцогддог.

21. David Smock. Private Peacemaking : USIP-assisted peacemaking projects of non-profit organizations. (U.S Institute of peace, 1998), 1 дэх тал
22. Eileen F. Babbitt. "Contributions of Training" in Peacemaking in International Conflict, ed. Zartman, I. William and Lewis J.Rasmussen. (Washington DC, United States Institution of Peace, 1997), 381-382 дахь тал
23. Ronald J. Fisher. "Interactive Conflict Resolution" in Peacemaking in International Conflict, eds. William I. Zartman and Lewis J.Rasmussen. (Washington DC, United States Institution of Peace, 1997), 244 дэх тал
24. Joseph V. Montville. "The Arrow and The Olive Branch: A Case For Track Two Diplomacy" Conflict Resolution: Track Two Diplomacy, eds. John W. McDonald and Diane B. Bendahmane Washington, DC.: Foreign Service Institute, 1987. 9 дэх тал
25. Дараа нь тусад нь бүлэг болгон үзэх тул энэ хэсэгт дэлгэрүүлсэнгүй. Э.Б
26. Мөн тэнд, 11 дэх тал
27. Kelman, "The Interactive Problem-Solving Approach" 505 дахь тал
28. Fisher, Interactive Conflict Resolution, 89 дэх тал
29. Kjell Skjelsbaek and Gunnar Fernann. "The UN Secretary General and the Mediation of International Disputes" in Resolving International Conflicts, ed. Jacob Bercovitch. (London, United Kingdom: Lynne Rienner Publishers, 1996), 76 дахь тал
30. Jenonne Walker. "International Mediation of Ethnic Conflicts". Ethnic Conflict and International Security, ed. Michael Brown. (Princeton, New Jersey: Princeton University Press, 1993), 168 дахь тал
31. Bryant Wedge. "Mediating Intergroup Conflict". In Conflict Resolution: Track two diplomacy, eds. John W.McDonald and Diane B.Bendahmane. (Washington, DC.: Foreign Service Institute, 1987), 36 дахь тал
32. Kelman, "Infomal Mediation by the Scholar/Pratitioner," 65 дахь тал
33. Fisher, Interactive Conflict Resolution, 101 дэх тал
34. Jacob Bercovitch and Allison Houston. "The Study of International Mediation". In Resolving International Conflicts, ed. Jacob Bercovitch. (London, United Kingdom: Lynne Rienner Publishers, 1996), 29 дэх тал
35. Bercovitch and Houston, 29-30 дахь тал
36. Hopman, 231-240 дахь тал
37. Jeffrey Z. Rubin. "Conclusion: International Mediation in Context". In Mediation in International Relations, eds. Jacob Bercovitch and Jeffrey Z. Rubin. (New-York, New-York: St. Martin's Press, 1992), 253 дахь тал